

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.16, 8.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг 1 дүгээр, “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Журмын хэрэгжилтийг хангахад шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт тус тус даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

Э.БАТШУГАР



Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦАХИМ ХУУДАС ХӨТЛӨХ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР БАЙРШУУЛЖ НИЙТЛЭХ, ШИНЭЧЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид "мэдээлэл хариуцагч" гэх) төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (цаашид "Цахим хуудас" гэх)-ыг хөтөлж, хуулиар байнга ил тод, нээлттэй байлгах аар заасан мэдээллийг байршуулах, нийтлэх, шинэчлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Мэдээлэл хариуцагч нь хууль болон энэ журам, Монгол Улсын стандарт "Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285"-д нийцүүлэн нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих талаар дотоод журам батлан мөрдүүлж болно.

1.3.Цахим хуудас хөтлөх, ашиглах, мэдээлэл шинэчлэхтэй холбоотой сургалтыг төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "Агентлаг" гэх), хөгжүүлэлт, засвар үйлчилгээ болон хэвийн үйл ажиллагааг "И-Монгол академи" УТҮГ (цаашид "Академи" гэх), техник хангамж, сүлжээний найдвартай, аюулгүй ажиллагааг "Үндэсний дата төв" УТҮГ (цаашид "Дата төв" гэх), цахим хуудасны бүтцийг баталж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нээлттэй мэдээллийг нийтлэх, шинэчлэх, цахим хуудас хөтлөх, тасралтгүй ажиллагааг мэдээлэл хариуцагчид тус тус хариуцан ажиллана.

Хоёр.Цахим хуудас хөтлөх хандах эрхийн зохицуулалт, чиг үүрэг

2.1.Цахим хуудасны хандах эрх нь дараах 4 түвшинтэй байна. Үүнд.

2.1.1.цахим хуудасны админ;

2.1.2.хяналтын админ;

2.1.3.байгууллагын админ;

2.1.4.байгууллагын бусад хэрэглэгч (6-аас ихгүй байна).

2.2."Цахим хуудасны админ" нь Академи байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.2.цахим хуудаст мэдээ мэдээллийг кирилл монгол, монгол бичиг, англи хэл дээр оруулах боломжтой байхаар хөгжүүлэх;

2.2.3.цахим хуудасны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гарсан тасалдал, саатал, алдаа, гэмтлийг бүртгэх, шаардлагатай тохиолдолд 3-5 хоногийн дотор холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран засварлах;

2.2.4.Агентлагаас ирүүлсэн цахим хуудас сайжруулах бодлогын даалгаврын дагуу системийн шинжилгээ хийж, шаардлагатай хөгжүүлэлтийг хийх.

2.3."Хяналтын админ" нь Агентлаг байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1.цахим хуудсанд мэдээлэл шинэчлэх үйл ажиллагааг мэдээлэл хариуцагч байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.3.2.цахим хуудас хөтлөх, мэдээлэл нийтлэхтэй холбогдох сургалт, нэвтрүүлэлтийн ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.3.3.цахим хуудасны "Онцлох мэдээ" буланг удирдаж, хяналт тавих;

2.3.4.мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн, хөгжүүлэлтийн бодлогын даалгаврыг боловсруулж, Академид хүргүүлэх;

2.3.5.цахим хуудасны хөгжүүлэлтийн ажлыг туршиж, нэвтрүүлэх;

2.3.6.цахим хуудасны бүтцийг боловсруулан, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.3.7.мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн хүсэлтэд үндэслэн ажлын 8 цагт багтаан хандах эрхийг тохируулж, удирдах.

2.4."Байгууллагын админ" болон "Байгууллагын бусад хэрэглэгч"-ийн хандах эрх нь Мэдээлэл хариуцагчид байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1.байгууллагын админ болон байгууллагын бусад хэрэглэгчийн хандах эрх хариуцах ажилтныг томилох;

2.4.2.байгууллагын админы эрх бүхий албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрд Агентлагт мэдэгдэж, тохиргоо хийлгэх;

2.4.3.өөрийн байгууллага, харьяа, салбар байгууллагын холбогдох хэрэглэгчдэд цахим хуудасны үйл ажиллагаа, ашиглалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.4.4.байгууллагын админ нь өөрийн байгууллагын бусад хэрэглэгчийн хандах эрхийг, харьяа, салбарын хэмжээнд байгууллагын админы хандах эрхийг удирдах, эрх авсан албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орох бүрд шинэчлэн

2.4.5.байгууллагын админ нь цахим хуудсанд системийн үндсэн боломжийн хүрээнд 3 хүртэлх цэсийг байгууллагын цэсэд үүсгэх эрхтэй байх бөгөөд энэ нь цахим хуудас дахь цэс болон мэдээлэлтэй давхардахгүй, мэдээллүүдийг баяжуулах, бусад төрлийн системүүдтэй холбох, тохиргоо хийх;

2.4.6.байгууллагын админ нь цахим хуудасны ашиглалт, хэвийн үйл ажиллагаа, түүний сайжруулалтай холбоотой санал, хүсэлтийг харьяа байгууллагын хэмжээнд нэгтгэн Агентлагт хүргүүлэх;

2.4.7.байгууллагын админ нь цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын эрсдэл саатаг гарсан тохиолдолд шалтгааныг даруй тодруулж, Академид мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авах,

2.4.8.байгууллагын бусад хэрэглэгч нь цахим хуудсанд өөрийн байгууллагын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн нийтэлж, үнэн зөв байдлыг хариуцах;

2.4.9.байгууллагын бусад хэрэглэгч нь цахим хуудасны ашиглалт сайжруулалттай холбоотой саналыг байгууллагын админд хүргүүлэх.

Гурав.Ил тод, нээлттэй мэдээлэл
байршуулж нийтлэх, шинэчлэх

3.1.Мэдээлэл хариуцагч нь дараах нээлттэй мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулж, тогтмол шинэчилнэ. Үүнд:

3.1.1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2-8.6-д заасан мэдээлэл;

3.1.2.цаг үеийн болон төлөвлөгөөт үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл;

3.1.3.байгууллагын удирдлага иргэдийг хүлээн авч уулзах цагийн мэдээлэл;

3.1.4.хүн, хуулийн этгээдээс гаргасан санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлтийн явцын мэдээлэл;

3.1.5.хуульд заасан бусад.

3.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд, бусад мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол хяналт тавина.

3.3.Цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийг Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системд автоматаар татан авах бөгөөд ил тод, нээлттэй байдлын (Шилэн индекс)-ийн үнэлгээнд ашиглана.

Дөрөв.Хяналт тавих

4.1.Агентлаг нь цахим хуудасны ашиглалт, шинэчлэл, үнэн зөв байдалд тогтмол хяналт тавьж, тайланг жил бүр цахим хөгжил, инновац, харилцаа

4.2.Дата төв нь цахим хуудасны техник хангамж, сүлжээний бэлэн байдал, найдвартай, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналт тавьж, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.3.Цахим хуудасны хөтлөлт, мэдээллийн шинэчлэлтэд хяналт тавихдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.19 дэх хэсэгт заасан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг баримтална.

Тав.Бусад зүйл


5.1.Цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг мэдээлэл хариуцагч бүрэн хариуцна.

5.2.Хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрснөөс бусад тохиолдолд хаалттай, хязгаарлалттай мэдээллийг цахим хуудсанд нийтлэхийг хориглоно.

5.3.Цахим хуудсанд хандах эрх бүхий ажилтан нь нэвтрэх нэр, нууц үгийг бусдад шийлжүүлэхийг хориглоно.

5.4.Цахим хуудсыг шинэчлэх, эсхүл шинээр үүсгэх тохиолдолд архивласан болон байршуулж нийтэлсэн нээлттэй мэдээллийг тухайн байршуулж нийтэлсэн огноогоор шинэ цахим хуудсанд хуулах, эсхүл устахгүй байхаар шинэчлэлийг хийнэ.

5.5.Цахим хуудасны мэдээлэл байгууллагын админы түвшинд устгах тохиолдолд цахим хуудасны админд мэдэгдэл хүргүүлнэ. Цахим хуудсанд хандах явцад мэдээлэл устах тохиолдолд гэм буруутай этгээд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.



Засгийн газрын 2026 оны 02 дугаар
сарын 04-ний өдрийн 41 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛАХ БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг Нийтлэг үндэсгэл

1.1. Энэ журам нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид "мэдээлэл хариуцагч" гэх), мөн хуулийн 8.2-8.6-д заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоох, 8.17-д заасан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл" (цаашид "Зөвлөл" гэх) нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8, 8.9, 8.10 дахь хэсэгт заасан цахим хуудас нь Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (цаашид "цахим хуудас" гэх) болон Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" систем (цаашид "нээлттэй мэдээллийн систем" гэх) байна.

1.3. Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн систем болон төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын цахим хуудасны бэлэн байдлыг хангана.

1.4. Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.16 дахь хэсэгт заасан "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг мөрдөнө.

1.5. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална:

1.5.1. шударга, хараат бус байх;

1.5.2. үнэлгээ нь нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан байх;

1.5.3. үнэлгээний тайлан, дүгнэлт нь ил тод байх;

1.5.4. үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, мэдээ тайланд үндэслэсэн байх;

1.5.5. зөвлөмж нь ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн байх;

1.5.6. ил тод байдлын тайлан нь үнэн зөв, нотлогдохуйц байх;

1.5.7.мэдээллийн үнэн зөв байдлыг мэдээлэл хариуцагч хариуцдаг байх.

**Хоёр.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг
үнэлэх шалгуур үзүүлэлт**

2.1.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.1.1.мэдээллийн хүртээмжтэй байдал-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 8.8-д заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх;

2.1.2.хугацаандаа нийтлэгдсэн байдал-нээлттэй мэдээллийг хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд олон нийтэд хүргэсэн эсэх;

2.1.3.мэдээллийн бүрэн бүтэн байдал-нээлттэй мэдээллийг хуулийн 8.2-8.6-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх;

2.1.4.эх сурвалжийн тодорхой байдал-хуульд заасан нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх.

2.2.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг үнэлэх дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлт бүхий Нээлттэй мэдээллийн системийн бүтэц, түүний хандах эрхийн түвшнийг цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

**Гурав.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын
үнэлгээ хийх аргачлал**

3.1."Мэдээллийн хүртээмжтэй байдал"-ыг (МХБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.1.1.нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.1.2.нээлттэй мэдээллийг ДУТУУ буюу зөвхөн цахим хуудаст нийтэлсэн бол 15 оноо, мэдээллийн самбарт нийтэлсэн бол 10 оноо, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол 5 оноо,

3.1.3.нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.2."Хугацаандаа нийтлэгдсэн байдал"-ыг (ХНБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.2.1.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.2.2.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол ДУТУУ буюу 10 оноо;

3.2.3. улирал бүр шинэчлэгддэг нээлттэй мэдээллийг нийтлээгүй, шинэчлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо;

3.2.4. хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.2.2, 8.3.3, 8.3.6-д заасан цахим хуудсанд байршсан, шалгуур хангасан, байнга шинэчлэгддэггүй мэдээллийн оноог бүрэн тооцно.

3.3. "Мэдээллийн бүрэн бүтэн байдал"-ыг (МБББ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.3.1. хуулиар 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 30 оноо, дутуу нийтэлсэн бол 15 оноо;

3.3.2. хуулийн 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээсэн мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 10 оноо, хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 5 оноо;

3.3.3. хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол 0 оноо.

3.4. "Эх сурвалжийн тодорхой байдал"-ыг (ЭСТБ) дараах аргачлалаар үнэлнэ:

3.4.1. нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.4.2. энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийн аль нэгийг нийтлээгүй бол ДУТУУ буюу 10 оноо;

3.4.3. энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хувийг шалгуур үзүүлэлтийн оноонд үндэслэн дараах аргачлалаар тооцож гаргана

3.6. Үнэлгээний ерөнхий болон хэсгийн дундаж оноо, хувийг үзүүлэлтүүдийн оноо, хувийн арифметик дунджаар тооцно.

3.7. Энэхүү журмын 3.5 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу үнэлгээг нээлттэй мэдээллийн системд автоматаар тооцоолох боломжийг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Нээлттэй мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийх, удирдлага, зохион байгуулалт

4.1. Нээлттэй мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийхдээ нээлттэй мэдээллийн системээр хянах бөгөөд хиймэл оюунд суурилсан дэвшилтэт

4.2.Мэдээлэл хариуцагч өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг энэ журмын 2 дугаар зүйлд заасан шалгуурын дагуу 3 дугаар зүйлд заасан аргачлалаар үнэлж, нээлттэй мэдээллийн системд илгээнэ.

4.3.Мэдээлэл хариуцагч цахим хуудас болон нээлттэй мэдээллийн нэгдсэн системд байршуулсан мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг хариуцна.

4.4.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээлэл хариуцагчийн нээлттэй мэдээллийн системд байршуулсан мэдээллийг дараагийн улирал, хагас жил жилийн эхний сард багтаан хянан баталгаажуулж, нээлттэй мэдээллийн системийн ил тод, нээлттэй байдал (Шилэн индекс)-ын үнэлгээг эрэмбэлэн ил тод байршуулна.

4.5.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нээлттэй мэдээллийн системийн ил тод, нээлттэй байдал (Шилэн индекс)-ын үнэлгээний үр дүнг тухай бүр Зөвлөлд хүргүүлнэ.

4.6.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг салбарын хэмжээнд сайд, нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулж, тэдгээрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж дотоод хяналт тавина.

4.7.Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухайн жилийн тайлангаа дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Зөвлөлд хүргүүлнэ.

4.8.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээнд хамаарах шилэн дансны хөтлөлтийн тухайн жилийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.17 дахь хэсэгт заасан орон тооны бус зөвлөлд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9.Зөвлөл нэгдсэн үнэлгээг хийхдээ ил тод, нээлттэй байдал (Шилэн индекс)-ын үнэлгээ, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, сайд, аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хамтатган хянаж, үнэлгээг баталгаажуулах бөгөөд үнэлгээнд өөрчлөлт оруулж болно.

4.10.Зөвлөл үнэлгээний нэгдсэн тайланг хуралдаанаараа хэлэлцэж, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй мэдээлэл хариуцагчид зөвлөмж хүргүүлнэ.

4.11.Мэдээлэл хариуцагч Зөвлөлөөс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, биелэлтийг 30 хоногийн дотор тайлагнана.

4.12.Зөвлөл мэдээлэл хариуцагчдын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн үнэлгээ, зөвлөмжийн хэрэгжилт, авах арга хэмжээний санал бүхий тухайн жилийн улсын хэмжээний нэгдсэн тайланг дараа оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулна.

4.13.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор хөндлөнгийн үнэлгээ болон судалгааг судалгааны байгууллага, мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

4.14.Зөвлөл үнэлгээ, судалгаа хийхэд шаардагдах зардлыг жил бүрийн байгууллагын төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

Тав.Хариуцлага

5.1.Нээлттэй мэдээллийг холбогдох журмын дагуу хугацаанд нь ил тод байршуулаагүй байгууллага албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

—oOo—

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
GOV.MN НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ АШИГЛАХ, ЭРХ ОЛГОХ АЛБАН ХААГЧИД МЭДЭЭЛЭЛ

Д/д	Байгууллагын нэр Рд	Хандах эрхийн түвшин	Овог, нэр	Албан хаагчийн регистрийн дугаар	Албан тушаал	Албан ёсны цахим шуудангийн хаяг	Утасны дугаар